



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 10 сарын 19 өдөр


Дугаар А/486


Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын 2.4.2.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Уламжлалт анагаах ухааны “Зүү эмчилгээний заавар”-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэхүү зааврыг мөрдөж ажиллахыг өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар (Я.Буянжаргал), Эрүүл яамны дэргэдэх Уламжлалт анагаах ухаан судлалын мэргэжлийн салбар зөвлөл (Д.Цэрэндагва)-д тус тус даалгасугай.
3. Тушаалыг хэрэгжүүлэхэд шаардагдах эмнэлгийн хэрэгслийг батлагдсан төсөвтөө багтаан, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Я.Амаржаргал)-д даалгасугай.

САЙД  Т.МӨНХСАЙХАН



2020-A-tushaal

• 141201919

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 10
дугаар сарын 19 -ны өдрийн 9/486
дугаар тушаалын хавсралт

ЗҮҮ ЭМЧИЛГЭЭНИЙ ЗААВАР

Нэг. Үндэслэл

Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын 2.4.2.8 дахь заалтыг хэрэгжүүлэн Монголын уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг орчин үеийн анагаах ухаантай хослуулан уламжлалт анагаах ухааны онол, эмнэлзүйн нотолгоонд суурилсан, үйлчлүүлэгч төвтэй тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, тасралтгүй үзүүлэхэд оршино.

Зүү эмчилгээ нь хэрэглэх хүрээ өргөн, үр дүн сайтай, хэмжигдэхүйц, хэрэглэхэд тохиромжтой аюул багатай орчин үед дэлхий нийтээрээ өргөн хэрэглэж байгаа эмчилгээний арга бөгөөд суваг хэрдсийн сургаал, зүүний сүвийн байршил, хатгаж төөнөх арга барилыг бүрэн төгс эзэмшсэний үндсэн дээр оношилох, эмчлэх, урьдчилан сэргийлэх салбар шинжлэх ухааны нэг юм.

Хоёр. Нэр томъёоны тайлбар

2.1 Энерги- амин эрчим хүч бөгөөд амьдралын туршид дотор эрхтэнүүдээс ялгаран үүсч (хоол хүнс дотоод шүүрлийн булчирхай ба 5 цул, 6 сав эрхтэнээс) хүн бүрт оршин тогтох нандин өвөрмөц хүч.

2.2 Ин- Ян- ертөнцийг бүрдүүлэгч бүх үзэгдэл юмсыг ин (билиг), ян (арга) хэмээн хоёр үндсэн бүлэгт хуваан хүний биеийн бүтэц үйл ажиллагааг эрүүл болон эмгэгийг хоёр талаас нь судалдаг онол.

2.3 Гадны өвчин үүсгэгч- хүний биед гадаад орчны нөлөөлөөс үүдэн үүсэх эмгэг өөрчлөлтийн түр зуурын шалтгаан. Үүнд төрөл бүрийн халдвар ба байгалийн хүчин зүйл болох салхи, хүйтэн, халуун, чийг, хуурайшилт, гал хамаарна.

2.4 Салхи- огцом үүсэлтэй хатгуулж хэсэж өвддөг ба өвдөлт нь салхи ихсэх үед ширүүсдэг хувирамтгай шинжтэй өөрчлөлтийг өгдөг өвчин үүсгэгч хүчин зүйл.

2.5 Чийг- биеийн хийн гүйдлийг саатуулан өөрчилж дэлүү ходоодны хэвийн үйл ажиллагааг алдагдуулдаг өвчин үүсгэгч хүчин зүйл.

2.6 Сэтгэлийн долоон гэм- хэт их баярлах, уурлах, түгших, санаа зовних, айх, уйтгарлах ба уйлах нь өвчин үүсгэх дотор шалтгаанд хамаарна.

2.7 Таван махбод- байгал, сав шим ертөнцийн үндсэн 5 махбод болох мод, гал, шороо, төмөр, ус нь өөр өөрсдийн өвөрмөц шинж чанарыг агуулсан ба бие биенээ үүсгэх эсвэл хязгаарлах холбоотой.

2.8 Таван махбодын эх хүүгийн холбоо- таван махбодын онолын дагуу үүсгэгч нь “эх”, үүсч буйг нь “хүү” гэж нэрлэдэг. Дээрх махбодын дарааллын дагуу мод нь галын эх, гал нь модны хүү болдог. Уг зарчмаар өвчний үүслийг тайлбарладаг, “эхийн өвчин хүүд” шилжинэ.

2.9 Төрөлхийн чи (qi) энерги- хүн бүрт төрөх үед нь бүрэлдэн буй болдог чи энерги юм.

2.10 Олдмол чи (qi) энерги- төрсний дараа хүний биед бүрэлддэг энергийг олдмол гэнэ.

2.11 Ерөнхий чи (qi) энерги- төрөлхийн болон олдмол энергийн нийлбэрээс бүрэлдэх амьдрах хүч чадал болон хөдөлгөөний идэвхийг буй болгодог чи энерги.

2.12 Суваг хэрдсийн чи (qi) энерги- суваг хэрдсийн тогтоцыг бүрдүүлэн үүсгэж түүний үйл ажиллагааг голлон хангагч чи энерги.

2.13 Өвчний эмгэг жам- өвчний үүсэл, хөгжил ба эдгэрэлтийг тайлбарладаг ойлголт.

2.14 Аргын (ян) давамгайлал- үйл ажиллагааны хэт идэвхжил, бодисын солилцооны түргэсэлт, халуун ихсэлт нь арга давамгайлсаны улмаас үүдэлтэй халуун хэтэрсний шинж болно.

2.15 Билгийн (ин) давамгайлал- үйл ажиллагаа суларч дулаан үүсэлт багасан хүйтэн давамгайлсан шинж илрэх нь билиг давамгайлсаны шинж болно.

2.16 Суваг хэрдсийн үйл ажиллагаа алдагдах- суваг хэрдсийн чи энерги ба цусны өөрчлөлт нь ихэнх эмгэг өөрчлөлтийн зүй тогтол болно.

2.17 Суваг хэрдсийн хямрал- суваг хэрдсийн чи энергийн хямрал нь биеийн ерөнхий энерги, цусны өөрчлөлт ба өвчин үүсгэнэ.

2.18 Салхи хүйтэн- бага зэрэг халуурч чичрүүлэх, толгой өвдөх, бүх бие өвдөх, хамар битүүрэх ба судал чичирсэн, долгиолсон болох нь салхи ба хүйтэн хавсарсан өвчин үүсгэгчийн улмаас үүсдэг.

2.19 Салхи халуун- өндөр халуурч жихүүцэх, ам цангах ба судал нь түргэн, долгиолсон болох нь биед гаднаас халуун ба салхи хавсран өвчин үүсгэснээс болдог.

2.20 Салхи хүйтэн чийг- суваг хэрдсийн түгжрэл үүсэн үе мөч өвдөж хөдлөхөд түвэгтэй болох нь салхи, хүйтэн, чийг хавсран нөлөөлсний улмаас үүснэ.

2.21 Халуун гэм- арга давамгайлж эсвэл билиг дутагдсаны улмаас үүсэх халуун шинж бүхий эмгэг өөрчлөлт.

2.22 Хүйтэн гэм- гол төлөв гадны өвчин үүсгэгч зүйл болон арга дутагдсаны улмаас үүссэн хам шинж болно.


2.23 Чийг хуурай- өвчин үүсгэгч чийг, хуурай 2 хүчин зүйл хавсран үүсгэж буй эмгэгийг хэлнэ. Голдуу дэлүү, ходоод, элэг цөс, олгой, арьсны эмгэгийг үүсгэнэ.

2.24 Долгиолсон судал- хүчтэй долгиолж ирэх ба аажим буух судал юм. Халуун их үед илэрдэг.

Гурав. Зүү эмчилгээний тухай ойлголт, үйлдэл, зарчим

3.1 Үндсэн ойлголт:

Зүү эмчилгээний суваг хэрдсийн систем нь үндсэн суваг 12, хослоогүй 8 суваг, 12 суваг шөрмөс, 12 арьсны хэсгээс бүрдэх бөгөөд хэрдэс суваг 15 орно.



3.2 Зүү эмчилгээний үйлдэл:

3.2.1 Суваг хэрдсийг нэвтрүүлэх нь суваг хэрдсийн зогсонгишлыг арилгаж энерги цусыг нэвтрүүлж, бие махбодийг хэвийн үйл ажиллагаанд оруулна.

3.2.2 Арга билгийг тэнцвэртэй байлгах нь ин янгийн тэнцвэрт байдлын алдагдлын үед түүнийг хэвийн байдалд оруулна.

3.2.3 Биеийн ерөнхий энергийг дэмжиж, гэмийн хорыг хөөж, биед нэвтэрсэн хорыг гадагшлуулж, биеийн энергийг сайжруулна.

3.3 Зүү эмчилгээний ерөнхий зарчим:

3.3.1 Доройг нөхөж, дүүрэнг хасах нь үндсэн энергээ дэмжих өвчин үүсгэгч гадна, дотор хорын энергийг хасах,

3.3.2 Халууныг арилгаж хүйтнийг бүлээцүүлэх нь халуун үед өнгөц хатгаж ба цус гаргаж халууны хорыг гадагшлуулж, хүйтэн эмгэгийн үед гүн хатгаж зүүг сүвд удаан үлдээж сувгийг бүлээцүүлж хүйтнийг арилгах,

3.3.3 Цул, сав эрхтэний үйл ажиллагааг хадгалан эмчлэх нь суваг хэрдсийн онол, таван махбодын онолд тулгуурлан хийх,

3.3.4 Цаг хугацаа, орон зай ба хувь хүнийг харгалзан эмчлэх нь хувь хүний бие махбодын онцлог, амьдарч буй газар орон, ахуй амьдралтай нь уялдуулан эмчилгээний аргаа сонгох зарчим юм.

Дөрөв. Зүү эмчилгээний оношилгоо, эмнэлзүй

4.1 Зүү эмчилгээний онолын дагуу асуух, сонсох, үзэх, тэмтрэх 4 аргаар оношилгоог хийнэ.

Оношилохдоо өвчний шалтгаан (гадар, дотор шалтгаан), өвчний байршил, өвчний явц (хүнд, хөнгөн), шинж чанараар (халуун, хүйтэн) зэргийг ялгана.

Өвчин үүсгэгч гэмийг тодорхойлж оношилно:

4.1.1 Салхи- хүйтэн гэмийн эмгэг нь бага зэрэг халуурч чичрүүлэх, толгой өвдөх, бүх бие өвдөх, хамар битүүрэх ба судал чичирсэн, долгиолсон болох нь салхи ба хүйтэн хавсарсан өвчин үүсгэгчийн улмаас үүсдэг.

4.1.2 Салхи- халуун гэмийн эмгэг нь өндөр халуурч жихүүцэх, ам цангах ба судал нь түргэн, долгиолсолтой болох нь биед гаднаас халуун ба салхи хавсарсан өвчин үүсгэснээс болдог.

4.1.3 Салхи- хүйтэн- чийгийн эмгэг нь суваг хэрдсийн түгжрэл үүсэн үе мөч өвдөж хөдлөхөд түвэгтэй болох нь салхи, хүйтэн, чийг хавсран нөлөөлсний улмаас үүснэ.

4.1.4 Халуун гэмийн эмгэг нь арга давамгайлж эсвэл билиг дутагдсаны улмаас үүсэх халуун шинж бүхий эмгэг өөрчлөлт гарахыг хэлнэ.

4.1.5 Хүйтэн гэмийн эмгэг нь гол төлөв гадны өвчин үүсгэгч зүйл болон арга дутагдсаны улмаас үүссэн хам шинж болно.

4.1.6 Чийг хуурай гэмийн эмгэг нь өвчин үүсгэгч чийг, хуурай 2 хүчин зүйл хавсран үүсгэх эмгэгийг хэлнэ. Голдуу дэлүү, ходоод, элэг цөс, олгой, арьсны эмгэгийг үүсгэнэ.

4.1.7 Дотоод шалтгааны эмгэг нь хэт их баярлах, уурлах, түгших, санаа зовних, айх, уйтгарлах ба уйлах зэргээс эмгэг өвчин үүсгэнэ.

Тав. Зүү эмчилгээ хийх арга

5.1 Хасах арга: өвчний гэмийн хөөж зайлуулах, бие махбодыг хэвийн үйл ажиллагаанд нь оруулах арга.

5.2 Нэмэх арга: хүний биеийн өвчин эсэргүүцэх чадварыг нэмэгдүүлэх, эд эрхтэний дорой буурай үйл ажиллагааг хэвийн байдалд оруулах арга.

5.3 Зүү эмчилгээний жорыг хэсэг газрын сүвээс сонгох, алслагдсан сүвээс сонгох, эмгэг шинжид тулгуурлан сүв сонгох гэсэн үндсэн 3 зарчмыг баримтална.

5.4 Зүү эмчилгээг төөнө эмчилгээ, бумба эмчилгээ, бусад зүүний аргуудтай хавсруулан хэрэглэж болно.

Зургаа. Зүү эмчилгээ судлалын тусламж үйлчилгээ

6.1 Заалт: Үрэвсэл дарах, өвдөлт намдаах, тайвшруулах, сэргээх, халуун бууруулах, бодисын солилцоог идэвхжүүлэх

6.2 Эсрэг заалт: тамир доройтсон өндөр настан хүмүүс, шалтгаан нь тодорхойгүй өндөр халуурах, хорт хавдар, элэг бөөрний дутагдал, цусны даралт ихдэх өвчний II, III үе, халдварт өвчний хурц үе, жирэмсэн эмэгтэй, нярай, сэтгэцийн эмгэгтэй хүмүүс, биеийн хүчний хүнд ажлын дараа

Долоо. Зүү эмчилгээг үзүүлэх байгууллага, хэрэглэгдэх зүйл

7.1 Зүү эмчилгээг уламжлалт анагаахын тусламж үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагад хийнэ. (Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1 /15.1.6, 15.1.9-өөс бусад/-д заасан эрүүл мэндийн байгууллага)

7.2 Хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгсэл: Зүү эмчилгээний ор, сандал, нэг удаагийн хэрэглээний ариун зүү, цахилгаан зүүний багаж, зүүний сүвээр хийх шингэн эмт бодис, чихний зүү, зүү баригч, галт зүүнд хэрэглэгдэх спиртэн дэн, асаагуур, дэвсэх-хучих даавуу, тахим болон хүзүүнд эвэх эвээс, зайлшгүй шаардлагатай эм тариа, тариуртай бикс, ариутгасан хөвөн, денатурат спирт, иод, биологийн идэвхт сүв тодорхойлогч, даралтны аппарат чагнуур, пульсоксиметр.

Найм. Зүү эмчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын үүрэг, үйл ажиллагаа

8.1 Монгол улсад мөрдөгдөж буй эрүүл мэндийн холбогдолтой хууль, тушаал, журам заавар, холбогдох стандартын хэрэгжилтийг ханган ажиллаж, хүн амд чанартай тусламж үйлчилгээ үзүүлнэ.

8.2 Зүү эмчилгээ үзүүлэхэд шаардлагатай өрөө, тасалгаа эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийг холбогдох стандартад заасны дагуу бүрдүүлэн тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлэх нөхцөлөөр хангана.

8.3 Зүү эмчилгээг эрүүл мэндийн байгууллага нь амбулаториор, өдрийн, хэвтүүлэн эмчлэх эмчилгээний хэлбэрээр үзүүлнэ.

Ес. Зүү эмчилгээний бэлтгэл ба үйлдлийн технологи

9.1 Агааржуулсан гэрэлтэй дулаан өрөөнд эмчилгээг хийнэ.

9.2 Эмчлүүлэгчийн сэтгэл санааг бэлтгэж хийх гэж буй үйлдлийг таниулна.

9.3 Эмчлүүлэгчийн эмчилгээ хийхэд тохиромжтой байрлалаар суулгах буюу хэвтүүлнэ.

9.4 Эмч гараа угааж, халдваргүйжүүлээд, тухайн эмгэгийг анагаахад болон эмчлүүлэгчид тохирох зүү сонгоно.

9.5. Зүү эмчилгээнд хэрэглэгдэх зүүний стандарт хэмжээ

Эмчлүүлэгчийн нас бие, өвчний онцлог зүү эмчилгээний хэлбэрт тохирсон (нарийн, арьсны, цэцгэн, гурвалжин) зүүг сонгоно.

9.5.1 Зүүний уртын хэмжээ

Цун	0.5	1.0	1.5	2.0	2.5	3.0	3.5	4.0	4.5
мм	15	25	40	50	65	75	90	100	115

9.5.2 Зүүний бүдүүн, нарийн хэмжээ

Дугаарын тоо	26	27	28	29	30	31	32	33
мм	0.45	0.42	0.38	0.34	0.32	0.30	0.28	0.26


9.6. Зүүний эмчилгээний практикт голчлон 28-30 дугаартай /0,32-0,38/ урт нь 1-3 цунгийн /25-75мм/ зүү хэрэглэх нь элбэг байдаг. Богино зүүг чих болон өнгөц хатгалтад, урт зүүг булчин мах зузаан гүн хатгах шаардлагатай сүвүүд болон хөндлөн хавж хатгахад сонгоно.

9.7. Зүү хатгах чиглэл:

9.7.1 эгц хатгах

9.7.2 ташуу хатгах

9.7.3 хөндлөн хатгах



9.8 Зүү эмчилгээнд хэрэглэгдэх зүүний бүтэц, төрлүүд:

9.8.1 Энгийн нэг удаагийн зүү

9.8.2 Арьсны зүү

9.8.3 Чихний зүү

9.8.4 Цахилгаан зүү

9.8.5 Гурвалжин зүү

9.8.6 Надо зүү

- 9.8.7 Хуйхны зүү
- 9.8.8 Цэцгэн зүү
- 9.8.9 Мөнгөн зүү
- 9.8.10 Алтан зүү

9.9 Зүү хатгах сүв түүний орчин тойрны арьсыг халдваргүйжүүлнэ.

9.10 Нарийн зүүг огцом хатгаж арьс цоолоод, зүүний мэдрэмж үүсгэн, өвчний онцлогт тохируулан нэмэх хасах, эсвэл тэгш аргаар зүүг хатгана. Эмчилгээний аргаас хамаарч зүүг 5-30 минут хүртэл сүвэнд байлгана. Нэг курс нь 10-30 удаа эмчилгээ хийнэ.

9.11 Цахилгаан зүү нь зүүний ар талын хэсгийг цахилгаан зүүний аппараттай холбоод гүйдлийн хүчийг тохируулна. Энэ нь зүүний сүвэнд цахилгааны үйлчлэлийг хавсарч эмчлэх арга юм. 15-20 минутаар нэг курс нь 10-20 удаа эмчилгээ хийнэ.

9.12 Усан зүү нь зүүний сүвэнд тариа хийж зүүний цочрол болон эмийн үйлдлийг хавсруулан хийж байгаа арга юм. Усан зүү нь эмт бодисыг тариурт соруулж, нэг сүвэнд 0,1-0,2мл байхаар тарина. Нэг удаад 3-4 сүв сонгож хийнэ. 7-10 удаа нэг курс болно.

9.13 Гарын зүү эмчилгээ нь гарын ар тал, болон алганд байрлах зүүний сүвэнд зүү эмчилгээ хийх арга юм. Гарын зүүг хатгахдаа сүв тодорхойлогчоор хамгийн эмзэглэлтэй хэсгийг илрүүлсний дараа зүүг огцом хатгаж арьс цоолон булчин шөрмөсөнд 0,5-1см хүртэл гүн хатгана. 20-30 минутаар 1 курс эмчилгээ нь 5-10 удаа хатгана.

9.14 Чихний зүү эмчилгээ нь чихний зүүний сүв дээр хатгаж цочроож өвчнийг эмчлэх, урьдчилан сэргийлэх аргын нэг юм. Чихний зүүнд арьсны нарийн зүүг хэрэглэнэ. Зүү наалдуулагчтай лентээр нааж 2-3 хонуулна. 2 цаг тутамд эмчлүүлэгч өөрөө эмчийн заасны дагуу цочрооно.

9.15 Толгойн зүү эмчилгээ нь толгойн арьсны хэсгийн өвөрмөц шугаман сүв дээр зүү эмчилгээ хийх арга юм. Толгойн зүүнд урт нарийн 35 мм-ийн голчтой зүүг хэрэглэнэ. Толгойн үстэй хэсэгт зүүг хатгадаг тул хэсэг газрын халдваргүйжүүлэлт болон хувийн ариун цэврийг сайтар сахина. 20-30 минутаар нэг удаа, курс эмчилгээ 10-20 удаа хийнэ.

9.16 Цэцгэн зүү нь нарийн зүүг 5, 7, 9 ширхэгээр багцлан сувгийн дагууд нэмэх хасах аргаар шивж хатгана. Нэг сүвэнд 5-7 удаа сувгийн дагууд 7-10 удаа, курс нь 5-7 удаа хатгана.

9.17 Гурвалжин зүүг бичил хануурт хэрэглэнэ. Хатгах сүвийн орчныг халдваргүйжүүлээд зүүгээр хатгаж 3-5 дусал цус гаргана.

Арав. Зүү эмчилгээ хийх биеийн байрлал сонгох, хатгах өнцөг

10.1 Гэдэргээ харж хэвтүүлэн хийх- толгой, нүүр, цээжин бие, хэвлийн хэсгийн бэлчир сүвүүдээр, дээд, доод хэсгийн сүвэнд эмчилгээ хийхэд тохиромжтой.


10.2 Биеийн хажуугийн байрлал- биеийн хажуугийн гар, хөлийн янгийн сүвэнд хатгахад тохиромжтой

10.3 Түрүүлгээ харуулан хэвтүүлэх байрлал-толгой, хүзүү, багана нуруу, өгзөгний хэсгийн сүв бэлчир, доод мөчний ар талын бэлчир сүвийг хатгахад тохиромжтой

10.4 Арагш налж суух байрлал- толгой, нүүрний болон хүзүүний өмнө хэсгийн бэлчир сүвийг хатгахад тохиромжтой

10.5 Урагш тонгойж суух байрлал- толгой, хүзүүний ар талын бэлчир сүвийг хатгахад тохиромжтой

10.6 Толгойгой гилжийлгэн суух байрлал- толгойн хажуу тал, хацар, чихний өмнө хойно байрлал бэлчир сүвэнд эмчилгээ хийхэд тохиромжтой.



Арван нэг. Анхаарах зүйл:

11.1 Өлөн болон хэт цатгалан, ядрах сэтгэл санаа тайван бус үед зүү эмчилгээ хийхгүй.

11.2 Цусны даралтыг эмчилгээний өмнө ба дараа тогтмол хянах.

11.3 Эмчилгээний үед дулаан хучих, эмчилгээний дараа 3-5 минут амраана.

11.4 Цус амархан гарах, гэмтлийн дараа цусыг зогсооход бэрх өвчтөнд зүү засал тохирохгүй. Гурвалжин зүү ба цэцгэн зүүг хэрэглэхдээ цусны бүлэгнэлтийг үзэх.

11.5 Хэт халахгүй даарахгүй байх.

11.6 Хүйтэн ус ундаа хэрэглэхгүй бороонд норохгүй байх.

11.7 Эмчилгээ хийлгэсэн өдөр бие, хэл, сэтгэлийн үйлийг хэтрүүлэхгүй байх.

11.8 3 сартай жирэмсэн эмэгтэйд хэвлийн доод хэсэгт хатгахгүй. 3 сараас дээш жирэмсэнд хэвлийн хэсэгт, ууц нурууны хэсэгт зүү хатгахгүй.

11.9 Нялх хүүхдийн зулай битүүрээгүй үед толгойн хэсэгт хатгахгүй.

11.10 Арьсны үрэвсэл, шархлаа, бэтэг буюу сорвитой хэсэгт хатгахыг цээрлэнэ.

11.11 Цээжний ар өвөр, нуруу хавирганы хэсэгт цул сав байрлаж байх тул гүн хатгах буюу эгц хатгахыг цээрлэнэ. Шээс хаагдах зэрэг өвчний үед хатгахад зохих чиглэл өнцөг, гүний хэмжээг сайтар анхаарч давсаг зэрэг цул савыг гэмтээхээс сэргийлэх хэрэгтэй. Нүдний хэсэг, хүзүү багана нуруу орчимд хатгах чиглэлийг зөв сонгох хэрэгтэй.

Арван хоёр. Зүү эмчилгээний хүндрэлээс сэргийлэх

12.1 Өвдөлт буюу зүү зоогдох- зүүг сүвд хатгасны дараа зүүг имрэх, татах бүлэх сугалах үед зүү зуурч чангаран өвдөлт өгөхийг хэлнэ. Энэ нь үйлчлүүлэгч хэт айсан, хатгасны дараа булчин хүчтэй агших, зүү тавих гарын арга дадал дутуугаас зүү булчингийн эдэд зуурч торох зэргээс болно. Ийм үед тухайн хэсгийн булчинг суллахын

тулд сүвийн ойролцоо зөөлөн дарах, зүүний зууралтын эсрэг талруу зөөлөн имирч зүүг суллаж авна.

12.2 Зүү муруйх- зүүг сүвд хатгах болон байлгах үед зүүний их бие биеийн дотор муруйхыг хэлнэ. Энэ нь ихэвчлэн гарын хатгах арга дадлыг дутуу эзэмшсэнээс зүүг хатгах хүч ба хурдыг хэтрүүлсэн зүү хатуу зүйлд тулах, зүүг хатгасны дараа биеийн байрлалыг өөрчлөх зэргээс муруйна. Ингэж муруйхад зүүг дагуулж алгуур сугалж авах, их муруйсан бол муруйг дагуулж хуучин байдалд авч ирж хэсэг хугацаанд булчинг суллаж дараа нь зүүг зөөлөн сугалж авна.

12.3 Зүү хугарах- зүү хугарч биед дотор үлдэхийг хэлнэ. Ихэнхдээ зүүний чанар муу зүүний уг хэсгээр нугарсан, хадгалалт буруу зэргийг сайтар шалгаагүйгээс, зүүний их биеийг далд ортол хатгах, хүчтэй хатгаж оруулснаар булчин цочирч хүчтэй чангарах, биеийн байрлалаа өөрчлөх зэргээс шалтгаалах хугарах аюултай.

12.4 Зүүнд ухаан балартах- үйлчлүүлэгчийн биеийн байдал дорой, хэт айх, өлөн байх, хэт ядарсан, их хөлөрсөн, гүйлгэсэн, цус алдсны дараа мөн зүүг тавих гарын арга дадал муугаас ширүүдүүлснээр толгой эргэн нүд эрээлжлэн царай нь цонхийж дотор муухайрч хий огиулах хөлрөх, зүрх дэлсэх дөрвөн мөч нь хөрөх, даралт нь буурах шинжүүд гарна. Энэ үед үүнээс урьдчилан сэргийлж үйлчлүүлэгчийг тайвшруулж, байрлалыг зөв сонгох, цөөн зүүний сүв сонгон, хөнгөн гарын аргаар хатгах, эмчилгээний явцад үйлчлүүлэгчийн биеийн байдлыг хянах, яаралтай тусламжийн эмчилгээг хавсран хийнэ.

12.5 Цус хуралт- зүү хатгасан хэсэгт цус гарч хавдахыг хэлнэ. Хатгах явцад зүүний үзүүрт цусны судас дайрнаас зүүг авах үед тэр хэсэгт цус гарч, арьсны өнгө хувирч хүрэнтэх, хурах шинжүүд гарна. Бага зэрэг цус гарч байдал хурууны өндгөөр 1-2 минут дарж зогсооно. Хуралтын хэмжээ том, өвдөлттэй бол хүйтэн жин тавьж цус тогтоогоод дараа нь бүлээн жин тавьж зөөлөн нухаж дарж өгнө. Урьдчилан сэргийлэхийн тулд зүүгээ сайн шалгах, зүүний сүвийн бэлчир орныг зөв тодорхойлох, аль болох судас хатгахгүй байх хэрэгтэй. Зүүг авсны дараа ариутгасан хөвөнгөөр зүүний сүвийн нүхийг нэн дариу дарна.

Арван гурав. Үйлдлийн гардан гүйцэтгэгч

13.1 Зүү эмчилгээний эмч байна.

13.2 Зүү эмчилгээний гам дэглэм, зөвлөмжийг эмч, сувилагч өгнө.

.....оОо.....